



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/219


Улаанбаатар хот

Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.14.7 заалт, Захирлын зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-Коосэн Технологийн коллежийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталж, 2017/2018 оны хичээлийн жилээс мөрдсүгэй.
2. Дээрх журмыг мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг СБЗГ-ын дарга /Д.Гэрэлт-Од/, ШУТИС-Коосэн Технологийн коллежийн захирал /Н.Ганбилэг/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

ШУТИС-ийн Захирлын 2017 оны 11 дүгээр сарын
24-ны өдрийн /2017... тоот тушаалын хавсралт



ШУТИС-КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, 2016 оны А/177 дугаар тушаалаар батлагдсан “Технологийн коллежийн сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “ШУТИС-ийн дүрэм”, ШУТИС-ийн Ректорын 2014 оны А/64 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” -ийг тус тус үндэслэн ШУТИС-Коосэн технологийн коллежид сургалт явуулах удирдлага зохион байгуулалт, суралцагчдыг элсүүлэх, тэдний мэдлэг чадварыг үнэлэх, дипломын төсөл, ажил хамгаалуулахтай холбогдон гарах бусад харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журманд тусгагдаагүй асуудлыг ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргана.

ХОЁР. СУРГАЛТЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. ШУТИС-Коосэн Технологийн коллежийн сургалтын үйл ажиллагааг ШУТИС-ийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, Сургалтын бодлого, зохицуулалтын газар, ШУТИС-Коосэн Технологийн коллежийн захирлын зөвлөл удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.
- 2.2. ШУТИС-Коосэн Технологийн коллежийн захиргаа нь суралцагчдын зөвлөл болон эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажиллана.
- 2.3. ШУТИС-Коосэн Технологийн коллеж нь бүрэн дунд боловсрол олгох сургалт болон дипломын дээд боловсрол олгох сургалтыг тус тус явуулна.
- 2.4. Боловсролын зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг ШУТИС-ийн Захирлын баталсан тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, "Сургалтын нэгдсэн хуанли"-г үндэслэн хичээлийн жил болон улирлаар төлөвлөн, зохион байгуулна.
- 2.5. Хичээлийн 1 цаг нь 45 минут байх ба хоёр цагийн хичээлийг завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулна.
- 2.6. Амралт баяр ёслол болон онцгой шаардлага гарсан үед хичээлийн зохицуулалтыг ШУТИС-Коосэн Технологийн коллежийн захирлын зөвлөл, ШУТИС-ийн захиргаа болон Төрийн захиргааны байгууллагуудын шийдвэрээр шийднэ.
- 2.7. Багш, ажилтнууд сургалт, зөвлөгөөн, олон нийтийн ажил, шуурхай цуглаанд заавал хамрагдах үүрэгтэй бөгөөд сургуулийн вэб сайт, байгууллагын албан ёсны цахим шуудан болон мэдээллийн самбарыг ашиглана.
- 2.8. Жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор багшийн ажлыг үнэлж дүгнэнэ.



- 2.9. Багшийн удирдан зохион байгуулах чадварыг харгалзан анги удирдуулна. 08 дугаар сарын 30-ны дотор анги удирдах багш нарыг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн томилж захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.10. Суралцагч, эцэг эх, багшаас гаргасан сургалтын чанар, хичээлээс гадуурх үйл ажиллагааны талаарх санал гомдлыг анги удирдсан багш, сургалт хариуцсан зөвлөх /сургалтын менежер/, захирал гэсэн шатлалын дагуу шийдвэрлүүлнэ.

ГУРАВ. ЭЛСЭЛТ

- 3.1. Суурь боловсрол, түүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэн /ЕБС-ийн 9-р анги төгсөгч/ болон бүрэн дунд боловсролтой /ЕБС-ийн 12-р анги төгсөгч/ ЭЕШ өгсөн иргэнийг тус тус элсүүлэх ба “ШУТИС-Коосэн Технологийн коллежийн элсэлтийн журам”-аар элсэгчдэд тавигдах шаардлагыг тухайн жилийн 3 дугаар сард багтаан нийтэд зарлана.
- 3.2. Элсэлтийн журмын болзол хангасан элсэгчийг ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 3.3. Шинээр элсэн суралцагчдыг СУРГУУЛЬ - ЭЦЭГ ЭХ-СУРАЛЦАГЧТАЙ байгуулах “Сургалтын гурвалсан гэрээ”-г байгуулан суралцуулна.
- 3.4. Шинээр элсэн суралцагчдад анги удирдсан багш томилон ажиллуулна. Анги удирдсан багш нь суралцагчдад суралцах үйл ажиллагаагаа төлөвлөхөд нь туслах үүрэгтэй.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХИЧЭЭЛИЙН СТАНДАРТ

- 4.1. Сургалтын төлөвлөгөө, бүтэц, агуулга, багц цагийн бүрэлдэхүүнийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/177 дугаар тушаалаар батлагдсан “Технологийн коллежийн сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын 2.2 дахь заалтыг баримтлан ШУТИС-ийн Захирал батална.
- 4.2. Тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд мэргэжлийн зориулалт, тодорхойлолт, суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, дадал, судлах хичээлийн жагсаалт, тэдгээрийн багц цаг, өмнөх хичээлийн холбоо зэргийг тусгана.
- 4.3. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн агуулга нэг хичээлийн жилд багтаан заах боломжтой байна.
- 4.4. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний өөрчлөлтийг Хөтөлбөрийн ерөнхий хорооны журмаар шийдвэрлэнэ.
- 4.5. Хичээлийн стандарт нь тухайн хичээлийн лекц, семинар, лаборатори, дадлага, бие даалтын агууламж, мөн хичээлээр судлах сэдэвчилсэн төлөвлөгөө, оюутныг үнэлэх багшийн үнэлгээ зэргийг багтаасан байна.



ТАВ. СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГИЙН ҮНЭЛГЭЭ

- 5.1. ШУТИС-Коосэн Технологийн коллежийн 1,2,3-р курсын суралцагчдын мэдлэгийг үнэлэхдээ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/309 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-ын 3.6 дугаар заалтыг баримтлана. 4,5-р курсын суралцагчдын мэдлэгийг үнэлэхдээ “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагаа зохицуулах журам”-ын 4.1, 4.2 дахь заалтад заасны дагуу үнэлнэ.
- 5.2. Хичээлийг судалж дууссаны дараа суралцагч уг хичээлийн хөтөлбөрт заагдсан мэдлэг, чадварыг хэрхэн эзэмшсэнийг үнэлэх улирлын шалгалтыг өгнө. Тухайн хичээлийн шалгалтанд хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд нэг удаа давтан шалгалт өгч болно.
- 5.3. Улирлын үнэлгээг тооцохдоо ирцийг 10 хувь, явцыг 60 хувь, улирлын шалгалтын үнэлгээг 30 хүртэл хувь гэж тооцон эдгээрийн нийлбэр дүнгээр гаргана.
- 5.4. Явцын үнэлгээ нь төсөлт ажил, даалгавар, аман болон бичгийн шалгалт хэлбэртэй байж болно.
- 5.5. Улирал бүрийн дүнгийн арифметик дунджаар жилийн эцсийн дүнг тооцно. Жилийн эцсийн дүнг суралцагчийн хувийн хэрэгт бичиж тэмдэглэнэ.
- 5.6. Суралцагч дараах шалтгаанаар явцын болон улирлын шалгалтаа өгч чадаагүй бол дахин шалгалт өгнө. Үүнд:
 - Өвчтэй байсныг нотлох эмчийн магадлагаатай бол
 - Хүнд гарз тохиолдсон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас
 - Хөл хорио цээр тогтоосон
- 5.7. Дунд боловсролын төгсөх ангид тухайн жилд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хичээлийн чиглэлийн дагуу улсын шалгалт болон анги дэвших шалгалтыг авч чанарын үнэлгээг тогтооно.
- 5.8. Улирлын үнэлгээний голч дүн нь 1.0-ээс доош бол суралцагчийг “Тухайн улиралд хангалтгүй суралцсан” гэж үзнэ. Хангалтгүй суралцсан суралцагчийн нэрийг “Анхааруулгын хуудас”-нд бичиж сануулах арга хэмжээ авна.
- 5.9. Захирлын нэрэмжит хуудсанд улирлын үнэлгээний голч дүн нь 3.6 ба түүнээс дээш амжилт үзүүлсэн суралцагчийн нэрийг оруулна.
- 5.10. Суралцагчийн ахиц, амжилтын үнэлгээг дүнгийн хуудсаар эцэг эх, асран хамгаалагчид улирал бүрийн эцэст хүргэнэ.

ЗУРГАА. ЧӨЛӨӨ ОЛГОХ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

6.1. Чөлөө олгох

- 6.1.1. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шаардлагатай бол чөлөө олгож болно. Чөлөөг сургалт хариуцсан зөвлөх /сургалтын менежер/ чөлөөний хуудас бичиж олгох ба чөлөөний хуудасгүй бол чөлөөг хүчингүйд тооцно. 5 хүртэлх өдрийн чөлөөг сургалт хариуцсан зөвлөх

ШУТИС-ийн Захирлын 2017 оны 11 дүгээр сарын
24-ны өдрийн /219... тоот тушаалын хавсралт



/сургалтын менежер/, 5-аас дээш өдрийн чөлөөг эцэг эх, асран хамгаалагчийн өргөдлийг үндэслэн захирал олгоно.

- 6.1.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээлд суугаагүй тохиолдолд дараах арга хэмжээнүүдийг авна.
- Хичээлийн нэг улиралд суралцагчийн хичээл таслалт 20 цаг болсон тохиолдолд оюутан хариуцсан ажилтан эцэг эхэд мэдэгдэх хуудас өгнө.
 - Хичээлийн нэг улиралд суралцагчийн хичээл таслалт 40 цаг болсон тохиолдолд багш нарын зөвлөлийн хурлаар оруулж сургуулиас хасах хүртэлх арга хэмжээ авна.
- 6.1.3. Суралцагч чөлөөтэй байх хугацааны хичээлийг бие даан нөхөж эзэмших үүрэгтэй.
- 6.2. Шилжилт хөдөлгөөн.
- 6.2.1. Гадаадын болон дотоодын их дээд сургууль, коллежоос шилжин ирэх хүсэлтэй суралцагчийн асуудлыг “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагаа зохицуулах журам”-ын 11.2 дахь заалтад заасны дагуу зохицуулна.
- 6.3. Суралцагчийг сургуулиас хасах.
- 6.3.1. Сургуулийн захиргаанаас дараах тохиолдолд суралцагчтай байгуулсан гэрээг цуцалж сургуулиас хасна. Үүнд:
- ШУТИС-ийн дүрэм, журмыг зөрчсөн бол
 - “Сургалтын гурвалсан гэрээ”-г зөрчсөн бол
 - Чөлөөний хугацааг хэтрүүлсэн бол
 - Шүүхээр гэм буруутай нь тогтоогдож ял эдлэхээр заагдсан бол
 - Суралцагч өөрөө сургуулиас гарахыг хүссэн тохиолдолд эцэг эхийн санал, өргөдлийг үндэслэх
 - Суралцагчийн нэр анхааруулгын хуудсанд дараалан 3 удаа бичигдсэн тохиолдолд сурлагаар тэнцэхгүй гэж үзэн сургуулиас хасна.
- 6.4. Суралцагч сургуулиас гарах тохиолдолд тойрох хуудас зуруулан, сургалтын төлбөрийн тооцоог “Сургалтын гурвалсан гэрээ”-ний дагуу шийднэ.

ДОЛОО. ТӨГСӨХ АНГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ, ҮНЭЛГЭЭ, ДИПЛОМ ОЛГОХ

- 7.1. Суралцагч 4 дүгээр курс төгсөхдөө судалгааны ажлын сэдвээ сонгоод харьяалагдах мэргэжлийн багш нарт мэдэгдэнэ. Суралцагчийн саналыг үндэслэн тухайн мэргэжлийн багш нар судалгааны ажлын сэдвийг сонгуулна.
- 7.2. Суралцагч 7 хоногт 1 удаа судалгааны ажлын семинар, хэвлэлийн семинарыг хийнэ.
- 7.3. Дипломын ажилд өгөх үнэлгээ, дээд боловсролын диплом олгох үйл ажиллагааг “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагаа зохицуулах журам”-ын холбогдох заалтуудаар /14.1, 14.2, 14.3, 14.4/ зохицуулна.

ШУТИС-ийн Захирлын 2017 оны 11 дүгээр сарын
24-ны өдрийн 4/219 тоот тушаалын хавсралт



НАЙМ. ДЭВШИН СУРАЛЦАХ

- 8.1. ШУТИС-Коосэн Технологийн коллежийг дипломын зэргээр төгссөн төгсөгч нь ШУТИС-ийн бакалаврын зэргийн сургалтад дэвшин шууд суралцах эрхтэй байна.
- 8.2. ШУТИС-Коосэн Технологийн коллежийн 3 дугаар курс төгссөн суралцагч нь цаашид их, дээд сургуульд дэвшин суралцах нөхцлийг хангахын тулд ЭЕШ өгсөн байна.
- 8.3. ШУТИС-Коосэн Технологийн коллежоос ШУТИС-ийн бакалаврын зэргийн сургалтаар дэвшин суралцсан оюутны дипломоос гүнзгийрүүлэн судлах хичээлийн 40 хүртэлх хувь, мэргэжлийн суурь хичээлийн 70 хүртэлх хувийн кредит болон үнэлгээг СБЗГ-ын хийсэн дүйцүүлэлтэнд үндэслэн тооцно.